



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/116

Чингис хот

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээний
зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 66 дугаар зүйлийн 66.1, “Газрын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 06 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын эрхийн гэрчилгээний зориулалт өөрчлөх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан Т.Үүрийнсолонгод холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар 1 иргэний 1 нэгж талбарыг өөрчилсүгэй.

2.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж хуулийн дагуу газрын зориулалтыг өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон, гэрээ байгуулахыг Газрын даамал (Ж.Эрхэмбаяр)-д зөвшөөрсүгэй.


3.Газрыг зориулалтын дагуу ашиглаж Газрын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд тогтмол төлж, жил бүр гэрээгээ дүгнүүлж байхыг газар эзэмшигч иргэдэд даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2020 оны 55 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР



Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
0.7 дугаар сарын 18-ны өдрийн /18/ тоот
захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээний зориулалт өөрчлөх
иргэдийн нэрсийн жагсаалт

д/д	эцэг/эх/-ийн нэр ,нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Өөрчилсон зориулалт	Хугацаа	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар
1	Төгөлдөр Үүрийнсолонго /СЮ95011506/	Гэр орон сууц, хашааны газар	3550м2	Хэнтий Хэрлэн 5-р баг, Хуучнаар үнээ фермийн зоорь	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	35	4330323